

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/113/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга	9
	2.11. Шилэн дансны мэдээлэл	10
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
	4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	14
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	15
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.АЛТАНЦЭЦЭГ
ТАНАА

2019.03.15 № 06/471
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ЫН 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 10-наас 2019 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Э.Цэвээнсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт 2019 оны 02 дугаар сарын 15 өдрийн 33/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь “Дотоодын түүхий эдэд түшиглэн газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулж, Монгол Улсын эдийн засгийг түлш шатахуунаар ханган, цаашилбал аж үйлдвэрийн цогцолборын томоохон бүрэлдэхүүн хэсэг болох нефть-химийн үйлдвэрийн суурийг бий болгох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

“Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 92 дугаар “Төрийн өмчит компани байгуулах тухай” тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 108 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулж үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгуулах, ашиглалтад оруулах;
- Үйлдвэрийг барьж байгуулах явцад болон ашиглалтад оруулахын өмнө шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчнийг гадаад улсад болон дотооддоо сургаж бэлтгэх;
- Стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, борлуулах;
- Үйлдвэрийг түүхий эдээр хангах;
- Түүхий тос дамжуулах хоолой барьж байгуулах;

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль
- Компаний тухай хууль
- Газрын тосны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь 2018 ондоо Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг мөрдөж ажиллаагүй, 2019 оны 01 дүгээр сараас эхлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг хийлгэн мөрдөн ажиллахаар болсон байна.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК -ний санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Интерактив ХХК-ийн “Даймонд” программ хангамж ашигладаг байна.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан 9 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь байгууллагын зардлын дансдад алдаа гарсантай холбоотой юм.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 70,4 сая бөгөөд түүний 1 хувь болох 7,0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдлийн түвшинг дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж үнэлсэн, 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцоноос 1 асуудлыг аудитын явцад залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Бүгд Найрамдах Итали Улсын “Кинетикс Техноложи” компаниас 505.8 сая төгрөг, Монгол-оросын хувь нийлүүлсэн нийгмэлэг Улаанбаатар төмөр замын барьцааны төлбөр 1,104.2 сая төгрөгийн авлагууд, Зам тээврийн хөгжлийн төв ТӨААТҮГ-ын хяналтын гэрээний

төлбөр 198.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/Мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	15,226.80	
2	Төлбөрийн акт тогтоосон	3	13,352.57	
	Дүн	6	28,579.37	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Зардлын данстай холбоотой

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн захирлын 2018 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 08 дугаар тушаалаар томилогдсон Ч.Энхтуяагийн үндсэн цалинг 0,197 сая гэж илүү олгосон нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалын хавсралтын 6 дугаарт “Хэрэв ажилтан дундаж цалин хөлсийг тодорхойлох хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар /өвчтэй, чөлөөтэй байсан гэх мэт/ бүрэн ажиллаагүй, эсхүл ажилтны ажилласан хугацаа нь дундаж цалин хөлс тодорхойлохоор заасан хугацаанд хүрэхгүй тохиолдолд тухайн хугацаанд авсан цалин хөлсний нийлбэр дүнг ажилтны жинхэнэ ажилласан өдөр /цаг/-ийн тоонд хувааж нэг өдөр /цаг/-ийн дундаж цалин хөлсийг тодорхойлно” гэж заасны зөрчсөн.

Шийдэл: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох эздээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Асуудал 2: Зардлын данстай холбоотой

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн “Нийгмийн даатгалын тайланг хугацаандаа тайлагнаагүй” гэсэн актны төлбөр 50.0 мянган төгрөг, Жолооч Булганы “Зөрчлийн тухай хуулийн 14.7.31 буюу хурд хэтрүүлсэн торгууль 60.0 мянган төгрөгийг тус тус байгууллагаас гаргаж төлүүлсэн нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1. “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдэл: Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.”Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна” гэж заасны дагуу холбогдох эздээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Асуудал 3: Зардлын данстай холбоотой

Нэр бүхий 5 ажилтаны цалин ээлжийн амралтын олговрыг давхардуулж 13,045.2 мянган төгрөгийг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалт, Эрүүл мэнд Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2000 оны 166-р тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох заавар” 2-д “Ажил олгогч нь бүх ажилтныг ажлын жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлэх бололцоогоор хангаж, эдлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдэл: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох эздээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2019 онд үргэлжлэн хэрэгжих төслийн гэрээ хийсэн Төрийн өмчийн 4 газрын гэрээнд дурдсан ажлын гүйцэтгэл ,биелэлтэнд анхаарал хандуулах.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 22 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит ХХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан. Үүнд: Зээлээрх хөрөнгө оруулалтын санхүүжилт 102,771.7 сая төгрөгөөс Тээврийн хэрэгсэл, тавилга 294.8 сая төгрөг, авто зам барих 26,600.0 сая төгрөг, төмөр зам барих 61,909.2 сая төгрөг, дэд станц, цахилгаан хангамжийн ажил 3,270.0 сая төгрөг, үйлдвэрийн талбай бэлдэх, үйлдвэрийн болон усан хангамжийн худгийг хамгаалах 5,941.2 сая төгрөг, техник технологийн байнгын хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний 3,521.2 сая төгрөг, Төслийн хүрээнд хийгдэх зөвлөх үйлчилгээ 1,235.0 сая төгрөг , Үйл ажиллагааны санхүүжилт 1,149.8 сая төгрөгөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшил 521.1 сая төгрөг, гадаад, дотоод албан томилолт 263.7 сая төгрөг, бусад зардалд 365.0 сая төгрөгөөр батлагдсан байна.

Гүйцэтгэлээр Тээврийн хэрэгсэл, тавилга 105.6 сая төгрөг, авто зам барих 12,940.4 сая төгрөг, төмөр зам барих 33,675.4 сая төгрөг, дэд станц, цахилгаан хангамжийн ажил 3,842.8 сая төгрөг, техник технологийн байнгын хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний САГ-2019/113/СТА-ТӨҮГ

1,379.4 сая төгрөг, авто зам, төмөр зам, дэд станц, цахилгаан хангамжийн ажлуудыг гүйцэтгэлээр нь олгосон, үйлдвэрийн талбай бэлдэх, үйлдвэрийн болон усан хангамжийн худгийг хамгаалах, төслийн хүрээнд хийгдэх зөвлөх үйлчилгээний ажлууд 2019 онд хийгдэхээр хойшлогдсон, үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 717.6 сая төгрөг байгаа нь орон тоо дутуу ажилласан, тогтмол зардал, гадаад, дотоодын албан томилолтын ажиллах хугацаа нь 2019 онд гүйцэтгэхээр болж өөрчлөгдсөнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн “www.shilendans.gov.mn/монгол газрын тос боловсруулах үйлдвэр төаанб” цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 Концессийн мэдээлэл, Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэлд нийт 9 мэдээлэл байршуулснаас 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд худалдан авалтын мэдээллийг тухай бүр оруулаагүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 3 зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Жолоочийн замын хуудасны тооцоо бодоогүй замын хуудсыг бүрэн бөглүүлээгүй явсан ажилтаны гарын үсэг байхгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу 4,4 сая төгрөгийн шатахуун зарлагадсан нь “Иж бүрэн байх”, “Оршин байх” “Тодруулга ба толилуулга” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн зардлыг үр ашиггүй зарцуулах, зардал хэтрэх, төсвийн зардал буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, жолоочийн замын хуудасны тооцоог тухайн хугацаанд нь бодож хэвших.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллахаар 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 71/19 тоот албан бичиг ирүүлсэн.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Албан томилолтын зам хоногийг тооцоог 1.7 сая төгрөгийг илүү олгосон нь “Иж бүрэн байх”, “Оршин байх” “Тодруулга ба толилуулга” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийн зардлыг үр ашиггүй зарцуулах, зардал хэтрэх, төсвийн зардал буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, зам хоногийн тооцоог батлагдсан тогтоол, журмын дагуу тооцож олгох.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллахаар 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 71/19 тоот албан бичиг ирүүлсэн.

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Д.Алтанцэцэг нь 2018 оны 01 дугаар сарын 01-нээс 2,4 сая төгрөгний үндсэн цалин авч байгаад 2018 оны 07-сарын 01-нээс хойш үндсэн цалинг 5,5 сая төгрөгөөр тогтоож 9.0 сая төгрөг илүү олгосон нь “Үнэлгээ”, “Үнэн зөв байдал” “Тодруулга ба толилуулга” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 196 дугаар “Журам батлах тухай” тушаалын 6 дугаар хавсралт “Төсөл хэрэгжүүлэх ажилтнуудын ажлын хөлсний жишиг”-т “Нарийн мэргэжлийн ажилтаны сарын үндсэн ажлын хөлсний хэмжээг 4.000.0 мянган төгрөгөөр тогтоосон”-г, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны 22 дугаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай” тогтоолын 1 дүгээр хавсралтын 10 дугаарт Нэг ажилтаны дундаж цалин 2,584.7 мянган төгрөгөөр тогтоосон заалтуудыг тус тус зөрсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Үндсэн цалин хөлсийг илүү олгосон байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллахаар 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 71/19 тоот албан бичиг ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	101,180,587.35	627,942,193.04
1.1.2	Дансны авлага	2,730,000.00	505,854,200.84
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,975,631.35	1,000,011.44
1.1.4	Бусад авлага	0.00	1,104,297,916.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	737,154.88	5,092,281.55
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	15,500,000.00	1,200,000.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	122,123,373.58	2,245,386,602.87
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	41,385,879.55	53,083,330,111.96
1.2.2	Биет бус хөрөнгө	5,538,566.20	6,682,582,269.70
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	46,924,445.75	59,765,912,381.66
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	169,047,819.33	62,011,298,984.53
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	47,000,000.00	703,874,240.84
2.1.1.2	Цалингийн өглөг	843,165.02	0.00
2.1.1.3	Татварын өр	8,739,972.72	4,878,898.98
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	2,068,421,451.19
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	62,339,647.96	0.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	118,922,785.70	2,777,174,591.01
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	53,155,796,719.38
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	53,155,796,719.38
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	10,000,000.00	10,000,000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	6,677,600,000.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	40,125,033.63	-609,272,325.86
2.3.11	Эздийн өмчийн дүн	50,125,033.63	6,078,327,674.14
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	169,047,819.33	62,011,298,984.53

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	438,635,100.04	62,489,647.96
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	438,635,100.04	62,489,647.96
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	29,858.53	5,767,686.62
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	363,141,333.45	578,658,686.02
11	Санхүүгийн зардал	663,000.39	56,321,491.02
12	Бусад зардал	27,039,059.00	75,730,830.31
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-159,965.10	-6,366,918.06
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	47,661,600.63	-648,820.590.83
19	Орлогын татварын зардал	7,536,567.00	576,768.66
20	Татварын дараах ашиг (алдагдал)	40,125,033.63	-649,397,359.49
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	40,125,033.63	-649,397,359.49
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	40,125,033.63	-649,397,359.49
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			40,125,033.6	40,125,033.63
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	10,000,000		40,125,033.6	50,125,033.63
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
11	Залруулсан үлдэгдэл	10,000,000			
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-649397359,4	-649397359,4
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		6,677,600,000		6,677,600,000
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	10,000,000	6,677,600,000	-649397359,4	6,078,327,674.1

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	460,650,756.3	460,650,756.3
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	460,650,756.3	460,650,756.3
1.1.6	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,143,535,485.1	1,143,535,485.1
1.2.1	Ажиллагчдад төлсөн	364,693,442.9	364,693,442.9
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	53,592,756.4	53,592,756.4
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	16,245,094.0	16,245,094.0
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,036,167.9	4,036,167.9
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,404,502.0	3,404,502.0
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	44,536,226.1	44,536,226.1
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	657,027,295.7	657,027,295.7
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-682,884,728.7	-682,884,728.7
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	5,767,686.6	5,767,686.6
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	5,767,686.6	5,767,686.6
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	45,085,647,942.5	45,085,647,942.5
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	105,558,220.0	105,558,220.0
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	44,980,089,722.5	44,980,089,722.5
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-45,079,880,255.8	-45,079,880,255.8
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	46,333,462,985.7	46,333,462,985.7
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	46,333,329,202.2	46,333,329,202.2
3.1.3	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	133,783.5	133,783.5
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	43,936,395.4	43,936,395.4
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	37,528,841.7	37,528,841.7
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	6,407,553.7	6,407,553.7
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	46,289,526,590.3	46,289,526,590.3
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	526,761,605.7	526,761,605.7
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	101,180,587.3	101,180,587.3
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	627,942,193.0	627,942,193.0

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.03.15	Аудитын нэр: "Монголын газрын тос боловсруулах үйлдвэр" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2019/113/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	"Монголын газрын тос боловсруулах үйлдвэр" хязгаарлагдмал хариуцлагатай	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Захиралын 2018 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 08 дугаар тушаалаар Ч.Энхтуяаг 2018 оны 2 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн үндсэн цалин 2500.0 мянган төгрөгөөр цалинжуулсан ажлын 8 өдөр ажилласан байхад /2дугаар сар ажлын 19 хоногтой байсан/ үндсэн цалинг 1250.0 мянган төгрөг гэж 197.36 мянган төгрөг гэж илүү олгосон байна	0.19	Төлбөрийн акт тогтоох	Нягтлан бодогч	Б.Баярмаа
2	2018оны 1.30-ны өдрийн Нийгмийн даатгалын улсын байцаагчийн НД-н тайланг хугацаандаа тайлагнаагүй гэсэн актны төлбөр болох 50.0 мянган төгрөг, жолооч Булган "Зөрчлийн тухай хуулийн 14.7.31 буюу хурд хэтрүүлсэн торгууль зэргийг байгууллагаас гаргаж төлүүлсэн	0.11	Төлбөрийн акт тогтоох	Нягтлан бодогч	Б.Баярмаа
3	Жолоочийн замын хуудасны тооцоо бодоогүй замын хуудсыг бүрэн бөглүүлээгүй явсан ажилтаны гарын үсэг байхгүй	4.4	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Баярмаа
4	Д.Алтанцэцэгийн үндсэн цалинг 2018 оны 07 дугаар сарын 01-нээс хойш 5,500.0 мянган төгрөгөөр тогтоосон	9.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Д.Алтанцэцэг
5	Нэр бүхий 5 ажилтаны цалин ээлжийн амралтын олговрыг давхардуулан олгосон	13.0	Төлбөрийн акт тогтоох	Нягтлан бодогч	Б.Баярмаа
6	Нийт томилолтын зардлыг шалгахад 12 удаагийн томилолтын зам хоногийн тооцоог илүү олгосон	1.8.	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Баярмаа
	ДҮН	28.6			